



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчиж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур 618.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэгт заасныг зөрчиж найдваргүй болох эрсдэлтэй авлага үүсгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 19, 21, 27, 30, 33, 34, 48, 49 дүгээр зүйлд заасныг зөрчиж 22,575.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийтдээ 23,194.2 /Хорин гурван тэрбум нэг зуун ерэн дөрвөн сая хоёр мянга/ сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн дүнг 2019 оны гуравдугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

2.1. “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохиох ажлын төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Шалгалтаар илэрсэн холбогдох зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн удирдах албан тушаалтнуудад хариуцлага тооцох;

2.3. Компанийн дүрэмд заасан хяналт тавих чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн дотоод аудитын холбогдох ажилтнуудад хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах;

3. “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөрд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удаа

дараа зөрчсөн холбогдох албан тушаалтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.3. Компанийн хөрөнгийг зохистой удирдаж авлага өглөгийг бууруулж ажиллах, нэг жилээс дээш хугацаатай авлагыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх;

3.4. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох талаар санал боловсруулан танилцуулж байх;

3.5. Ашиглалтгүй байгаа шатахуун хадгалах 4 агуулах, онгоц сумлагч 2 автомашиныг үйл ажиллагаандаа ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

3.6. Онгоцны түрээсийн гэрээ байгуулахдаа техникийн болон төлбөрийн нөхцөлийг тохиролцох, түрээсийн гэрээнээс өмнө онгоцыг буцаах үед гарах эрсдэлийг тооцож баталгаажуулах зэргээр гэрээний эрх зүйн үндэслэлийг сайжруулах;

3.7. Борлуулагч агентуудтай хийсэн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй агентуудын гэрээг цуцлах, агентуудаас авах авлагыг гэрээнд заасан алданги тооцдог тооцооллын процессыг санхүүгийн програм хангамжид нэвтрүүлэх;


3.8. “МИАТ” ТӨХК-ийн эзэмшлийн, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5,257,725.00 төгрөгийн анхны өртөгтэй, 2,166,902.00 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй /дахин үнэлгээ хийгдээгүй/ “Ачаа шуудангийн барилга”-ыг хууль бусаар бусдын эзэмшилд шилжүүлж, улмаар нурааж, оронд нь барилга бариулсан асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т “эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл” гэж заасныг үндэслэн Иргэний хэрэг үүсгэн холбогдох байгууллага, хуулийн этгээдээс барилгын үнийг нэхэмжлэх, газрын эзэмшлийг баталгаажуулан дахин үнэлгээ хийлгэх;

3.9. Хуулийн маргааны асуудлыг компанид ашигтай байдлаар шийдвэрлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулж, шаардлагатай тохиолдолд хуулийн зөвлөх үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зөвлөх үйлчилгээний тендер зарлаж зөвлөх үйлчилгээ авч байх.

3.10. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасгай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны дүгээр сарын 8-ний өдрийн
№ 8. Дугаар тогтоолын хавсралт



“Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Зөрчлийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	МИАТ хувьцаат компани 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Air Lease Corporation компанитай Боинг 767-300 28149 дугаартай агаарын хөлгийг 40 сарын хугацаатай түрээслэн ашиглах үндсэн гэрээ болон нэмэлт гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үргүй зардал гаргасан	Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал, Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс, Хуулийн хэлтэс	-	Оngoцны түрээсийн гэрээ байгуулахдаа техникийн болон төлбөрийн нөхцөлийг хатуу тохиролцох, түрээсийн гэрээнээс өмнө онгоцыг буцаах үед гарах эрсдэлийг тооцож баталгаажуулах зэргээр гэрээний эрх зүйн үндэслэлийг сайжруулах;
2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэгт заасныг зөрчиж найдваргүй авлага үүсгэсэн	Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал, Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс	-	Борлуулагч агентуудтай хийсэн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй агентуудын гэрээг цуцлах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;
3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчиж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур үндсэн хөрөнгө бэлтгэсэн	Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал, Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс, Худалдаа хангамжийн хэлтэс	618.5	Хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулах, батлагдсан төлөвлөгөөний дагуу үндсэн хөрөнгө олж авах;

4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 19, 21, 27, 30, 33, 34, 48, 49 дүгээр зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Худалдаа хангамжийн хэлтэс, бусад хэлтэс	22,575.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж, журмын дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гаргаж байх.
Зөрчил, дутагдлын нийт дүн				23,194.2